



Ү А Г

**Засгийн газрын агентлагийн
зохион байгуулалт, бүтцийн
зохистой байдал, үр нөлөө**

**Зарим агентлагуудын бүтэц,
зохион байгуулалтыг өөрчлөх
боломж байна**

**Үндэсний аудитын газрын 2006 оны бүтээгдэхүүн, ажил, үйлчилгээний
төлөвлөгөөний дагуу хийсэн зохион байгуулалтын аудитын тайлан**

Улаанбаатар 2006 он

ҮАГ -1/2006/13-ЗБА

Агуулга

<u>Тайланг бэлтгэсэн:</u>	Товчилсон үгсийн жагсаалт	2
ҮАГ-ын Нэгдүгээр газар	Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй	3
<i>Тэргүүлэх аудитор Д.Ганбилэг</i>	Бүлэг 1	
<i>Аудитын менежер Ж.Батсайхан</i>		
<i>Ахлах аудитор С. Сэрчхорол</i>	Агентлагийн зайлшгүй хэрэгжүүлэх чиг үүрэг, үзүүлэх үйлчилгээ тодорхойгүй байна	4-10
<i>Аудитор С. Андруш</i>	Бүлэг 2	
<i>Шинжээч Ц. Эрдэнэчулуун</i>		
<i>Ж.Сарантуяа</i>		
2006 оны 11 дүгээр сар	Зарим агентлагуудын чиг үүрэг, үйлчилгээ давхардаж байна	11-15
	Бүлэг 3	
Тайланг ҮАГ-ын вэб сайт-аас үзнэ үү:		
<u>www.mnao.pmis.gov.mn</u>	Агентлагийн үйл ажиллагааг зохих ёсоор үнэлж дүгнэхгүй байна	16-17
<i>Аудитын тайлан, дүгнэлттэй холбоотой асуудлаар нэмж тодруулах, асууж лавлах зүйл байвал 261839 дугаарын утас, 323266 дугаарын факсаар харилцана уу.</i>	Холбогдох байгууллагаас ирүүлсэнсанал	18
	Хавсралт	19-24
ХАЯГ:		
<i>Үндэсний аудитын газар Засгийн газрын 4 дүгээр байр, Бага тойруу-6, Улаанбаатар-46 Монгол Улс</i>		

Товчилсон үгсийн жагсаалт

УИХ	Улсын Их Хурал
МОНЦАМЭ	Монголын цахилгаан мэдээ
СЯ	Сангийн яам
ТЗҮААЭГ	Төр засгийн үйлчилгээ, аж ахуй эрхлэх газар
ДБҮААГ	Дипломат байгууллагын үйлчилгээ, аж ахуйн газар
БХБНААГ	Барилга, хот байгуулалт, нийтийн аж ахуйн газар
АМХЭГ	Ашигт малтмалын Хэрэг эрхлэх газар
ЗТАЖЯ	Зам, тээвэр, аялал жуулчлалын яам
ХХААЯ	Хүнс, хөдөө аж ахуйн яам
БСШУЯ	Боловсрол, соёл шинжлэх ухааны яам
БОЯ	Байгаль орчны яам
ТӨХ	Төрийн өмчийн хороо
СЗХ	Санхүүгийн зохицуулах хороо
ШБӨХЗГ	Шударга бус өрсөлдөөнийг хянан зохицуулах газар
ХЗДХЯ	Хууль зүй дотоод хэргийн яам
АББЗСТ	Албан бус боловсролын зайны сургалтын төв
БҮТ	Боловсролын үнэлгээний төв
ТАЗ	Төрийн албаны зөвлөл
ҮХЦ	Үндсэн хуулийн цэц
СЕХ	Сонгуулийн Ерөнхий хороо
ЦАУЗБУК	Цагаатгах ажлыг удирдан зохион байгуулах улсын комисс
ГХОГ	Гадаадын хөрөнгө оруулалтын газар
УМХГ	Улын мэргэжлийн хяналтын газар
БХБЯ	Барилга, хот байгуулалтын яам
ГТХЭГ	Газрын тосны хэрэг эрхлэх газар
УБТЗХНН	Улаанбаатар төмөр замын хувь нийлүүлсэн нийгэмлэг
ҮХЯ	Үйлдвэр худалдааны яам
НХХЯ	Нийгэм хамгаалал хөдөлмөрийн яам
ТЭХЯ	Түлш, эрчим хүчний яам

Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй

Үндэсний аудитын газрын 2006 оны бүтээгдэхүүн, ажил, үйлчилгээний төлөвлөгөөг үндэслэн Төрийн аудитын тухай хуулиар тодорхойлсон Үндэсний аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд Засгийн газрын агентлагуудын бүтэц, зохион байгуулалтын зохистой байдал, үр нөлөөнд аудит хийлээ.

Энэхүү аудитын зорилт нь Засгийн газрын агентлагуудын бүтэц, зохион байгуулалтад дүн шинжилгээ хийж үр нөлөөг дээшлүүлэх санал зөвлөмж боловсруулахад чиглэгдлээ.


Аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу 30 агентлаг 6 төвийн үйл ажиллагааг хамруулан авч үзэв.

Аудитыг Төрийн хянан шалгалтын стандарт, гүйцэтгэлийн аудитын журам, гарын авлагад заасны дагуу холбогдох хүмүүстэй ярилцлага хийх, тайлбар нотолгоо авах, нотлох зүйлийг нэгтгэх, бүлэглэх зэргээр шинжилж дүгнэлт гаргах арга зүйг ашиглан хийлээ.

Аудитын явцад ХБНГУ-ын Берлин муж улсын Аудитын шүүхийн Хяналт шалгалтын 7 дугаар газрын захирал Х. Кох хүрэлцэн ирж мэргэжил, арга зүйн зөвлөгөө өгч ажилласан.

Төрийн хяналт шалгалтын стандарт, гүйцэтгэлийн аудитын журам, гарын авлагад заасны дагуу аудитын дүн, дүгнэлтэд дэмжлэг болох нотлох зүйлс, холбогдох мэдээ судалгааг ажлын баримт материалд хавсаргав.

1.2 Засгийн газрын бүтэц бүрэлдэхүүн өөрчлөгдсөнтэй холбогдуулан Төрийн захиргааны байгууллагын тогтолцоо, бүтцийн ерөнхий бүдүүвчийг УИХ 2004 онд дахин шинэчилж, дараахь байдлаар тогтоожээ.



1.3 2002 онд тохируулагч агентлаг 8, хэрэгжүүлэгч агентлаг 33, бүгд 41 агентлаг байсан бол 2004 онд тохируулагч 11 агентлаг, хэрэгжүүлэгч 19 агентлаг, бүгд 30 агентлаг байгуулагджээ.

1.4 Ингэхдээ 8 агентлагийн харъяаллыг өөрчилж зохион байгуулалтыг хэвээр үлдээсэн, 17 агентлагийг татан буулгаж, чиг үүрэг, үйлчилгээг нь өөр байгууллагад шилжүүлсэн байна. Үүний зэрэгцээ, агентлагийг татан буулгасан боловч чиг үүрэг, үйлчилгээг нь үргэлжлүүлэн хэрэгжүүлэх 6 төв шинээр бий болсон байна.

Эдгээр төвүүдийг байгуулсан шийдвэрүүдийг хүснэгтэд харуулав.

№	Төвийн нэр	Байгуулагдсан шийдвэрийн			Шийдвэрт тусгагдсан үндэслэл
		Нэр	Он	Дугаар	
1	Эрчим хүчний судалгаа хөгжлийн төв	Засгийн газрын тогтоол	2004	203	Агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 6.3-т "Хуульд өөрөөр заагаагүй бол агентлагийг өөрчлөн байгуулах, татан буулгах асуудлыг Улсын Их Хурлаас зөвшөөрсөн төрийн захиргааны байгууллагын тогтолцоо, бүтцийн ерөнхий бүдүүвчийн дагуу Засгийн газар шийдвэрлэнэ".
2	Мэдээлэл харилцаа холбооны хөгжлийн төв	Засгийн газрын тогтоол	2004.10.20	207	
3	Авто замын хяналтын судалгааны төв	Засгийн газрын тогтоол	2004	202	

4	Тээврийн үйлчилгээний төв	Засгийн газрын тогтоол	2004	202	
5	Барилга, нийтийн аж ахуйн хөгжлийг дэмжих төв	Засгийн газрын тогтоол	2004	201	
6	Эрүүл мэндийн хөгжлийн үндэсний төв	Засгийн газрын тогтоол	2004	236	

1.5 Засгийн газрын Агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн дээрх заалт хуучин агентлагийн чиг үүрэг, үйлчилгээг нь үргэлжлүүлэн хэрэгжүүлж буй төвүүдийг байгуулах үндэслэл болж чадахгүй байна.

1.6 Эдгээр төвүүдийн бүтэц, орон тоо, зардлыг холбогдох сайд баталж байна.

1.7 Агентлагийн зохион байгуулалтаар ажиллаж байгаад татан буугдсан боловч төв нэрээр ажиллаж буй 6 байгууллагын зөвхөн орон тоо, цалингийн зардал хэрхэн өөрчлөгдсөн талаарх судалгааг доорх хүснэгтэд үзүүлэв.

Шинээр байгуулагдсан төвүүдийн орон тоо, цалингийн зардлыг агентлаг байх үетэй харьцуулсан судалгаа

(мянган төгрөг)

№	Татан буугдсан агентлаг	Байгуулагдсан төв	Агентлаг байх үеийн (2004 он)			Төв болсон үеийн (2005 он)			Бууралт			Өсөлт			Тайлбар
			Орон тоо	Цалин	1 хүнд ногдох сарын дундаж цалин	Орон тоо	Цалин	1 хүнд ногдох сарын дундаж цалин	Орон тоо	Цалин	1 хүнд ногдох сарын дундаж цалин	Орон тоо	Цалин	1 хүнд ногдох сарын дундаж цалин	
1	Түлш эрчим хүчний Ерөнхий газар	Эрчим хүчний судалгаа хөгжлийн төв	107	171026.4	159.8	89	182362.9	204.9	18			11336.5	45.1	1-10 сарын дүн	
2	Шуудан цахилгаан холбооны газар	Мэдээлэл харилцаа холбооны хөгжлийн төв	32	62324.8	162.3	32	61928.1	161.3		396.7	1.0				
3	Авто замын газар	Авто замын хяналт, судалгааны төв	68	87781.6	143.4	57	72973.7	142.2	11	14807.9	1.2			1-9 сарын дүн	
4	Тээврийн газар	Тээврийн үйлчилгээний төв	121	119300.0	82.2	228	259372.1	94.8				107	140072.1	12.6	
5	Барилга хот байгуулалт, нийтийн аж ахуйн газар	Барилга, нийтийн аж ахуйн хөгжлийг дэмжих төв	53	78748.8	123.8	54	92494.2	142.7				1	13745.4	18.9	
6	Эмнэлгийн тусламжийн удирдах газар	Эрүүл мэндийн хөгжлийн үндэсний төв	139	149143.4	89.4	84	122203.6	121.2	55	26939.8				31.8	
Нийт			520	668325.0	760.9	544	791334.6	867.2	84	42144.4	2.22	108	165154.0	108.5	

1.8 Судалгаанаас үзэхэд агентлагийг төв болгож өөрчилснөөр нийт дүнгээрээ орон тоо 108, цалингийн зардал 165,1 сая төгрөгөөр, сарын дундаж цалин 108,5 мянган төгрөгөөр тус тус өссөн байна.

1.9 Шинээр байгуулагдсан 6 төвийн Эрүүл мэндийн хөгжлийн үндэсний төв улсын төсвөөс, бусад 5 төв нь өөрийн үйл ажиллагааны орлогоос санхүүжиж байна.

1.10 Дээрх төвүүд төрийн өмчийн байр ашиглан төрийн нэрийн өмнөөс ажил үйлчилгээ үзүүлж 3436,6 сая төгрөгийн орлого олж, үйл ажиллагаагаа санхүүжүүлж байна. Төвүүдийн санхүүжилтийн эх үүсвэр, ашиглаж буй байрны талбайн талаархи судалгааг дор үзүүлэв.

- 1.14 Өмнө нь хийгдсэн зохион байгуулалтын өөрчлөлт, орон тооны цомхотгол гол төлөв төсөв, мөнгө хэмнэхэд чиглэгдэж байжээ.
- 1.15 Цаашид бүтэц, зохион байгуулалтын өөрчлөлт хийхдээ иргэдэд үзүүлэх төрийн үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах, шуурхай болгоход анхаарах нь зүйтэй байна.
- 1.16 Түүнчлэн, бүтэц, зохин байгуулалтын өөрчлөлтийг зөвхөн төрийн захиргааны төв, нутгийн захиргааны байгууллагын хүрээнд төдийгүй мөн тэдгээрийн харьяа төсөвт байгууллага, төрийн өмч давамгайлсан компанийг хамруулан хийх шаардлага байна.
- 1.17 Засгийн газрын Агентлагийн эрх зүйн байдлын тухай хуульд заасанчлан Засгийн газрын агентлагийг УИХ-аас зөвшөөрсөн Төрийн захиргааны байгууллагын тогтолцоо, бүтцийн ерөнхий бүдүүвчийн дагуу ерөнхий сайд, сайдын саналыг үндэслэн Засгийн газар байгуулах ёстой.
- 1.18 Агентлаг байгуулах саналд дараахь зүйл тусгагдсан байх шаардлагатай.
Үүнд:
- ❖ Тухайн агентлаг төрөөс зайлшгүй хэрэгжүүлэх чиг үүрэг, үзүүлэх үйлчилгээг хэрэгжүүлэх үндэслэл;
 - ❖ Тухайн агентлагийн үйл ажиллагаа Монгол Улсын нутаг дэвсгэрийн хэмжээнд хэрэгжих;
 - ❖ Агентлагийн үйл ажиллагаа төрийн захиргааны бусад байгууллагын чиг үүрэг, үйлчилгээтэй давхардахгүй байх.
- 1.19 Одоо ажиллаж буй агентлагуудыг шинээр зохион байгуулахдаа агентлаг байгуулах тухай саналыг эрхэлсэн сайд, Ерөнхий сайд нар албан ёсоор гаргаж байсан эсэхийг тодруулахаар холбогдох байгууллагад хандсан боловч шаардлага хангахуйц нотлох зүйл олж авч чадсангүй.
- 1.20 Агентлаг байгуулах тухай саналыг хууль тогтоомжийн дагуу иж бүрэн боловсруулж, зохих шат дамжлагаар хянуулж батлуулаагүй нь түүнийг үндэслэл, тооцоо муутай урсгалаар зохион байгуулсан байж болох эрсдэлийг илтгэж байна.
- 1.21 Агентлаг байгуулах нэг үндэслэл нь тухайн агентлагийн хэрэгжүүлэх чиг үүрэг, үзүүлэх үйлчилгээ төрөөс зайлшгүй хэрэгжүүлэх чиг үүрэг, үйлчилгээ мөн эсэх юм.
- 1.22 Төрөөс зайлшгүй хэрэгжүүлэх чиг үүрэг, үйлчилгээний жагсаалт, шалгуурыг тогтоогоогүй байгаа нь одоо ажиллаж буй агентлагуудын хэрэгжүүлж буй чиг үүрэг, үзүүлж буй үйлчилгээг төрөөс зайлшгүй хэрэгжүүлэх шаардлагатай эсэхийг тогтоож дүгнэлт өгөхөд хүндрэл учруулж байна.
- 1.23 Иймд ардчилал, зах зээлийн эдийн засгийн харилцаа, хувийн хэвшил, иргэний нийгмийн хөгжлийн өнөөгийн түвшинд төрөөс зайлшгүй хэрэгжүүлэх чиг үүрэг, үйлчилгээний жагсаалт, тэдгээрт тавих шалгуурыг гаргаж тогтмол шинэчилж байх шаардлагатай гэж үзэж байна. Ингэхдээ төрийн нуруун дээрх ачааллыг аль болох хөнгөлөх, төрийн оролцоог багасгах, зарим чиг үүрэг,

үйлчилгээг хувьчлах, хувийн хэвшлийн болон төрийн бус байгууллагуудаар гэрээгээр хийлгэх зэрэг боломжуудыг харгалзан үзэх нь зүйтэй юм.

1.24 Ингэснээр Засгийн газрын үйл ажиллагааны чиглэл, бүтцийн ерөнхий тогтолцоог улам боловсронгуй болгох нөхцөл бүрдэнэ.

Бүлэг 2

Зарим агентлагуудын чиг үүрэг, үйлчилгээ давхардаж байна

Агентлагийн хэрэгжүүлж буй чиг үүрэг, үзүүлж буй үйлчилгээ бусад байгууллагын чиг үүрэг, үйлчилгээтэй давхардахгүй байх ёстой.

2.1 Агентлаг, төвүүдийн чиг үүрэг, үзүүлж буй үйлчилгээг бусад байгууллагын чиг үүрэг, үзүүлж буй үйлчилгээтэй харьцуулж, тэдгээр чиг үүрэг үйлчилгээг нь төрөөс зайлшгүй хэрэгжүүлэх шаардлагатай эсэхийг судалж үзэв.

2.2 Бусад байгууллагатай чиг үүрэг нь давхардаж байгаа 7 байгууллагыг татан буулгах, нэгтгэх, чиг үүргийг нь холбогдох байгууллагад шилжүүлэх, Төмөр замын хэрэг эрхлэх газар, Тээврийн үйлчилгээний төвийн зарим чиг үүргийг бусад хуулийн этгээдээр гэрээний үндсэн дээр гүйцэтгүүлэх, Ус цаг уур, орчны шинжилгээний газар, Удирдлагын академийг агентлагын бүтэц зохион байгуулалтаас гаргаж боловсрол, бусад шинжлэх ухааны байгууллагын жишгээр ажиллуулах боломжтой гэж үзлээ.

2.3 Зарим агентлаг, төвүүдийг бүтэц, зохион байгуулалтын хувьд хэрхэн өөрчлөх санал, түүний үндэслэлийг хавсралтаар үзүүлэв.

2.4 Бүтэц зохион байгуулалтыг нь өөрчлөхийг санал болгож буй дээрх байгууллагуудаас нийт 388 орон тоо хэмнэгдэх тооцоо гарч байна. (доорх хүснэгтийг үз):

Хүснэгт 2.1

№	Өөрчлөлт оруулахаар санал болгож буй			Өөрчлөх санал	Хэмнэх орон тоо
	Агентлагийн нэр	Газар, хэлтсийн нэр	Орон тоо		
1	Төрийн өмчийн хороо	Тамгын газар	28	Татан буулгах	28
		Төрийн өмчийн удирдлага, хувьчлалын газар	19	Сангийн яаманд шилжүүлэх	
		Төрийн өмчийн бүртгэл, хяналт шалгалтын газар	18	Татан буулгах	18
		Дүн	65		46
2	Мэдээлэл харилцаа холбоо технологийн газар	Бодлого төлөвлөлтийн хэлтэс	5	Зам тээвэр, аялал жуулчлалын яаманд чиг үүргийг нэгтгэх	
		Бодлого, хэрэгжилт, зохицуулалтын хэлтэс	4	Зам тээвэр, аялал жуулчлалын яаманд чиг үүргийг нэгтгэх	
		Төрийн захиргаа, хамтын ажиллагааны хэлтэс	9	Татан буулгах	9
		Дүн	18		9
3	Шударга бус өрсөлдөөнийг хянан зохицуулах газар	Хуулийн хэлтэс	5	Татан буулгах	5
		Тамгын хэлтэс	11		11
		Хамтын ажиллагааны хэлтэс	2		2
		Үйлдвэрийн салбарын хэлтэс	4	Үйлдвэр худалдааны яаманд нэгтгэж ажиллуулах	
		Нийгмийн салбарын хэлтэс	5		
		Дэд бүтцийн салбарын хэлтэс	5		

		Бүгд	32		18
4	Төмөр замын хэрэг эрхлэх газар	Бодлого хэрэгжилт хамтын ажиллагааны хэлтэс	3	Татан буулгаж чиг үүргийг ЗТАЖЯ-ны Тээврийн газарт шилжүүлэх	3
		Тээвэр зохицуулалт, хяналтын хэлтэс	3		3
		Захиргаа, санхүүгийн хэлтэс	9		9
		Дүн	15		15
5	Тээврийн үйлчилгээний төв	Хяналт шалгалтын алба	26	Улсын мэргэжлийн хяналтын газрын Дэд бүтцийн хяналтын улсын албанд нэгтгэх	
		Тээвэр зохицуулалтын хэлтэс	32	Хотын тээврийн удирдах газарт нэгтгэх	
		Тамгын хэлтэс	19	Татан буулгах	19
		Санхүүгийн хэлтэс	19	Татан буулгах	19
		Техникийн хяналтын хэлтэс	132	Хувьд шилжүүлэх	132
		Дүн	228		170
6	Сэргээгдэх эрчим хүчний төв	Эрдэм шинжилгээний хэлтэс	23	Эрчим хүчний судалгаа хөгжлийн төвд нэгтгэж агентлаг болгох	
		Төсөл-Маркетингийн хэлтэс	3	Татан буулгах	3
		Захиргаа, санхүүгийн хэлтэс	10		10
		Бүгд	36		13
7	Орон сууцны үндэсний төв	Захиргаа, санхүүгийн хэлтэс	10	Барилга, хот байгуулалтын яаманд нэгтгэж ажиллуулах	10
		Орон сууцны хэлтэс	16		16
		Хөрөнгө оруулалтын хэлтэс	16		16
		Бүгд	44		44
8	Усны хэмнэлтийн төв	Захиргаа, санхүүгийн хэлтэс	5	Усны хэрэг эрхлэх газарт нэгтгэх	5
		Усны нөөц бүртгэлийн алба	4	Татан буулгах	4
		Ус ашиглалтын алба	7	Татан буулгах	7
		Бүгд	16		16
9	Авто замын хяналт судалгааны төв	Зам гүүрийн барилга засварын хяналтын алба	18	Татан буулгаж мэргэжлийн хяналтын газрын чиг үүрэгт нэгтгэх	18
		Судалгаа шинжилгээний алба	17		17
		Захиргаа аж ахуйн алба	22		22
		Бүгд	57		57
		Нийт	525		388

2.5 Зарим агентлагууд дотоодын зөвлөхийн орон тоо бий болгон ажиллуулж үр ашиггүй зардал гаргаж байна. Тухайлбал, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх Ерөнхий газарт 2 орон тоотой 7,2 сая, Иргэний бүртгэл, мэдээллийн Улсын төвд 1 орон тоотой 1,8 сая, Төрийн өмчийн хороонд 1 орон тоотой 2,1 сая, Мэргэжлийн хяналтын газар 1 орон тоотой 2,1 сая, Онцгой байдлын Ерөнхий газарт 1 орон тоотой 2,1 сая төгрөгийн зардалтай зөвлөх ажиллаж байна. Онцгой байдал эрхэлсэн болон Мэргэжлийн хяналтын асуудал эрхэлсэн сайд нар зөвлөх болон ажлын албатай ажиллаж байна

2.6 Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 15.2-т “Агентлагийн даргыг гадаад улсын ижил төрлийн байгууллага, олон улсын болон бусад байгууллагад туршлага судлах, мэргэжлийн сургалтад явах, хурал

зөвлөгөөнд оролцохыг Монгол Улсын сайд шийдвэрлэнэ”, 15.4-т “Агентлагаас гадаад улсын ижил төрлийн байгууллага, олон улсын байгууллагаас мэргэжилтэн зочид төлөөлөгч урих асуудлыг Монгол Улсын сайд шийдвэрлэнэ” гэж зааснаас үзэхэд агентлагуудын гадаад харилцааны асуудлыг холбогдох яамдын гадаад харилцааны хэлтэс, газрууд үндсэнд нь гүйцэтгэх боломжтой байна.

Хүснэгт 2.2: Зарим агентлагуудын гадаад харилцааны газар, хэлтсийн орон тоо, цалингийн зардал

№	Агентлагийн нэр	Гадаад харилцааны газар, хэлтсийн ажилтны	
		Тоо	Цалингийн зардал 2005 он (сая.төг)
1	Улсын Гаалийн ерөнхий газар	3	5.9
2	Үндэсний архивын газар	1	2.1
3	Хил хамгаалах ерөнхий газар	1	1.7
4	Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар	1	2.1
5	Ус, цаг уур орчны шинжилгээний газар	2	4.2
6	Усны хэрэг эрхлэх газар	1	1.9
7	Нийгмийн даатгалын ерөнхий газар	1	1.9
8	Хүүхдийн төлөө үндэсний газар	1	2.0
9	Төмөр замын хэрэг эрхлэх газар	1	1.9
10	Шударга бус өрсөлдөөнийг хянан зохицуулах газар	2	2.7
11	Иргэний бүртгэл мэдээллийн улсын төв	1	2.3
12	Иргэний нисэхийн ерөнхий газар	11	31.5
13	Цагдаагийн ерөнхий газар	4	9.4
14	Гадаадын хөрөнгө оруулалтын газар	3	5.7
	Бүгд	33	60.2

2.7 Дээрх агентлагуудын гадаад харилцааны асуудал хариуцсан ажилтнуудын ажил үүргийг харьяалах яаманд шилжүүлснээр 33 орон тоо, 60,2 сая төгрөг хэмнэх боломж байна.

2.8 Засгийн газрын байрын захиргаадыг “Төрийн үйлчилгээ” Улсын үйлдвэрийн газрын жишээгээр компани болгон ажиллуулбал орон тоо, төсөв хэмнэх боломж байна.

2.9 Тухайлбал Засгийн газрын доорх байруудыг нэгтгэж төрийн өмчит улсын үйлдвэр болгосноор дарга 4, нягтлан бодогч 4, аж ахуйн эрхлэгч 4, зохион байгуулагч 4, бүгд 16 орон тоо, 28,8 сая төгрөгийн цалингийн зардал хэмнэх боломж байна.

2.10 Одоогийн байдлаар ТЗҮААЭГ-ын харьяанд дор дурдсан Засгийн газрын байрын захиргаад ажиллаж байна:

Хүснэгт 2.3 Одоо ажиллаж буй Засгийн газрын байрны захиргаадын орон тоо, цалингийн зардал болон орлогын эх үүсвэр

№	Байгууллагын нэр	Нийт орон тоо	2006 оны төсөв сая төг	Цалин хөлс	Төсвөөс санхүүжих	Өөрийн орлогоос санхүүжих	Үйл ажиллагаа явуулж байгаа Төр Засгийн төв байгууллагууд
1	ЗГ-ын 3-р байр	30	143.6	41.6	143.6		БСШУЯ, БОЯ, Засгийн газар хоорондын Олон улсын төслийн байгууллага 2; 450 хүн
2	ЗГ-ын 4-р байр	26	112.8	40.6	112.8		ТӨХ, УАГ, СЗХ, ШБӨХЗГ, ХЗДХЯ, 350 хүн
3	ЗГ-ын 10-р байр	12	30.0	18.3		30.0	Төрийн сан, Боловсролын хүрээлэн, АББЗСТ, БҮТ, Соёл урлаг судлалын хүрээлэн, 90 хүн
4	ЗГ-ын 11-р байр	50	278.0	56.5	80.4	197.6	ТАЗ, ҮХЦэц, СЕХороо, ЦАУЗБКомисс, ГХОГ, МХАУТ, Хүний эрхийн комисс, Азоны хяналтын газар, Цөмийн энергийн төв, аж ахуйн нэгж, 350 хүн
5	ЗГ-ын 12-р байр	40	109.7	53.4	109.7		УМХГ, БХБЯ, Газрын тосны ХЭГ, Газрын харилцаа геодези зураг зүйн газар, Үл хөдлөх хөрөнгийн газар, 700 хүн
	Нийт	158	674.1	210.4	446.5	227.6	

2.11 Төрийн төв байгууллагуудын нийтлэг үйлчилгээг гэрээгээр гүйцэтгүүлэх жишиг бий болсон байна. Тухайлбал: “Төрийн үйлчилгээ” Улсын үйлдвэрийн газар аж ахуйн тооцоон дээр 3 дахь жилдээ ажиллаж 2005 онд төлөвлөсөн зорилтоо хангалттай биелүүлж ашигтай ажилласан байна.

2.12 Энэхүү Улсын үйлдвэрийн газар санхүүгийн болон үйлчилгээний гэсэн 2 багийн зохион байгуулалтаар 58 хүний бүрэлдэхүүнтэй ажиллаж СЯ, ҮХЯ, НХХЯ, ТЭХЯ, ЗТАЖЯамны санхүү, урсгал засвар болон цэвэрлэгээ үйлчилгээ, цахилгаан дулаан, цэвэр бохир усны шугам сүлжээ, спорт заал, үсчин цайны газар, галын аюулгүй байдлыг хангах зэрэг ажил үйлчилгээг хариуцаж байна.

2.13 Дээр дурдсан бүтэц зохион байгуулалтын өөрчлөлтийг хийснээр гарах хэмнэлтийг нэгтгэн тооцож үзвэл 451 орон тоо, 1526.6 сая төгрөгийн урсгал зардал, төрийн өмчийн байрнаас 3393.5 ам метр талбай тус тус хэмнэгдэхээр байна.

Хүснэгт 2.4: Агентлагуудыг татан буулгаснаар гарах хэмнэлт

№	Хэмнэлт гарах үндэслэл		Гарах хэмнэлт			
			Орон тоо	Урсгал зардал /сая.төг/	Үүнээс:	Ашиглагдаж буй төрийн өмчийн байр /ам.метр/
Жилийн дундаж цалин /сая.төг/						
1	Зарим агентлаг, төвүүдийг татан буулгах	Төрийн өмчийн хороо	46	286.5	91.3	360
		Шударга бус өрсөлдөөнийг хянан зохицуулах газар	18	44.3	27.9	120
		Мэдээлэл, харилцаа холбоо, технологийн газар	18	114,2	34,7	246,2

		Төмөр замын хэрэг эрхлэх газар	15	79.3	33.9	345.5
		Авто замын хяналт судалгааны төв	57	364,6	72,9	444,0
		Тээврийн үйлчилгээний төв	170	519.4	117.1	1246
		Сэргээгдэх эрчим хүчний төв	13	16.1	4.1	320
		Орон сууцны үндэсний төв	44	36.1	18.6	150
		Усны хэмнэлтийн төв	16	66.1	9.1	130
2	Зарим агентлагийн дотоодын зөвлөхийн орон тоог цомхотгох	Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар	2		7.2	
		Иргэний бүртгэл мэдээллийн улсын төв	1		1.8	
		Улсын мэргэжлийн хяналтын газар	1		2.1	
		Онцгой байдлын ерөнхий газар	1		2.1	
3	Зарим агентлагийн гадаад харилцааны асуудал хариуцсан нэгжийг татан буулгах	33		60.2		
4	Засгийн газрын байруудын удирдлагын бүтэц, зохион байгуулалтыг өөрчлөх	16		28.2		
5	Улсын мэргэжлийн хяналтын газрын Санхүүгийн хяналт шалгалтын хэлтсийг Сангийн яаманд нэгтгэх				32	
	Дүн	451	1526,6	511,2	3393,5	

Зарим агентлагуудын үйлчилгээний стандарт хангалтгүй байна

2.15 Агентлагуудын үйлчилгээний орчин иргэдэд үйлчлэх нөхцөлийг бүрдүүлж чадахгүй байна. Тухайлбал: Үндэсний татварын ерөнхий газар, Үндэсний архивын газар, Ашигт малтмал, газрын тосны Хэрэг эрхлэх газар, Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар, Иргэний бүртгэл мэдээллийн улсын төв, Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн газар зэрэг байгууллага гаднаа автомашины зогсоолгүй, иргэдийг хүлээн авч үйлчлэх хангалттай танхимгүй, байрлалын схемгүйгээс үйлчилгээг чирэгдэлгүй, хөнгөн шуурхай үзүүлж чадахгүй байна.

2.16 Чирэгдэлгүй, хөнгөн шуурхай үйлчилгээг нэвтрүүлэх үүднээс дээрх байгууллагын бүтэц зохион байгуулалтыг өөрчлөн боловсронгуй болгох, зарим чиг үүргийг төрийн бус байгууллагаар гүйцэтгүүлэх боломжтой талаархи иргэдийн санал шүүмжлэлийг судалж үзэх нь зүйтэй.

Бүлэг 3

Агентлагийн үйл ажиллагааг зохих ёсоор үнэлж дүгнэхгүй байна

- 3.1 Агентлагууд Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 12 дугаар зүйлд зааснаар улсын төсвөөс буюу өөрийн орлогоос гэсэн 2 эх үүсвэрээр үйл ажиллагаагаа санхүүжүүлж байна.
- 3.2 Аудитад хамрагдсан агентлаг, төвүүд төсвийн санхүүжилтийг хуулиар тогтоосон хэмжээнд нь бүрэн авч байжээ.
- 3.3 УИХ-ын 2004 оны 14 дүгээр тогтоолыг үндэслэн ЗТАЖСайдын 2004 оны 31 дүгээр тушаалаар Төмөр замын Хэрэг эрхлэх газрын үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөрийг баталж, Төмөр замын Хэрэг эрхлэх газрыг үйл ажиллагааныхаа орлогоор санхүүжих зарчмаар ажиллуулахаар шийдвэрлэсэн боловч ямар эх үүсвэрээр санхүүжигдэх нь тодорхойгүй байна.
- 3.4 Монгол-Оросын хувь нийлүүлсэн УБТЗН олон жилийн турш төмөр замын салбарт төрийн захиргааны болон аж ахуйн нэгжийн үйл ажиллагааг зэрэг гүйцэтгэж байсан юм.
- 3.5 Төмөр замын Хэрэг эрхлэх газар УБТЗХНН-ээс 4,7 сая төгрөг, 363,4 мянган ам долларыг эргэж төлөгдөх нөхцөлөөр хүүгүй зээлж үйл ажиллагаагаа санхүүжүүлж байна. Энэ зээлийг 2006-2008 онд төлж дуусгахаар харилцан тохиролцсон боловч одоогийн байдлаар УБТЗХНН-т төлбөр хийгдээгүй байна. Энэ нь Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 12.1 дэх заалт, ЗТАЖСайдын 2004 оны 31 дүгээр тушаалыг зөрчсөн байна.
- 3.6 Төсвийн ерөнхийлөн захирагч нар агентлагуудын нийлүүлсэн бүтээгдэхүүнийг гарсан зардалтай нь харьцуулан үнэлэлт, дүгнэлт өгч ажиллаагүй байна.
- 3.7 Агентлагуудаас Иргэний бүртгэл мэдээлийн улсын төв, Гадаадын иргэн харьяатын асуудал эрхлэх алба, Оюуны өмчийн газар, Ашигт малтмал, газрын тосны Хэрэг эрхлэх газар, Иргэний нисэхийн ерөнхий газар, Төмөр замын Хэрэг эрхлэх газар, Гадаадын хөрөнгө оруулалтын газар зэрэг агентлагууд орлогоороо зардлаа нөхөн ажиллаж байна.
- 3.8 Дээрх агентлагуудын цалингийн зардлыг харьцуулж үзэхэд харилцан адилгүй тогтоогдсон байна. Тухайлбал, Иргэний нисэхийн ерөнхий газрын зарим албан тушаалтны цалин бусад агентлагийнхаас 2-3 дахин өндөр тогтоогдсон байна. Цаашид дээрх агентлагуудаас орох орлогыг улсын төсөвт бүрэн төвлөрүүлж, зардлыг улсын төсвөөс санхүүжүүлэх нь зүйтэй байна.

Монгол Улсын Ерөнхий сайд М. Энхболдод дараахь зөвлөмжийг өгч байна:

1. Төрөөс зайлшгүй хэрэгжүүлэх чиг үүрэг, үзүүлэх үйлчилгээ, тэдгээрт тавигдах нийтлэг шаардлага, шалгуурыг тогтоох, түүнчлэн хувийн хэвшил, төрийн бус байгууллагаар гүйцэтгүүлэх боломжтой чиг үүрэг, ажил үйлчилгээний жагсаалтыг гаргах асуудлыг судалж зохих журмын дагуу шийдвэрлүүлэх
2. Одоо ажиллаж буй агентлагуудын чиг үүрэг, ажил үйлчилгээ төрөөс зайлшгүй хэрэгжүүлэх чиг үүрэг, ажил үйлчилгээ мөн эсэхийг хянаж, агентлагуудын бүтэц, зохон байгуулалтыг оновчтой болгох чиглэлээр холбогдох арга хэмжээ авах
3. Татан буугдсан агентлагуудын суурин дээр байгуулагдсан төвүүдийн эрх зүйн үндэслэл, статус, чиг үүрэг, үйлчилгээг хянаж, зохих арга хэмжээ авах

Сангийн сайд Н. Баяртсайханд дараахь зөвлөмжийг өгч байна:

1. Орлогоороо зардлаа нөхөн ажилладаг агентлагуудын орлогыг улсын төсөвт бүрэн төвлөрүүлж, төсөвт байгууллагуудын жишгээр ажиллуулах асуудлыг судалж, зохих журмын дагуу шийдвэрлүүлэх

Төсвийн Ерөнхийлөн захирагч нарт:

1. Агентлагийн нийлүүлсэн бүтээгдэхүүн, үйлчилгээг үнэлж, гэрээний биелэлтийг дүгнэж ажиллах

Холбогдох байгууллагаас ирүүлсэн санал



МОНГОЛ УЛС ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗАР

2006 оны 12 дугаар сарын 12-ны өдөр

Дугаар ...*Х08/2451*

Улаанбаатар-12
Утас: 262408
Факс: 976-11-310011

МОНГОЛ УЛСЫН БРӨНХИЙ АУДИТОР
Л.ЖАВЗМАА ТАНАА

Танай 1/429 тоотын хариу

Үндэсний аудитын газраас Засгийн газрын агентлагийн зохион байгуулалт, бүтцийн зохистой байдал, үр нөлөөний байдалд хийсэн аудитын тайлантай танилцлаа.

Аудитын тайлангийн зөвлөмжид тусгагдсан асуудлуудын талаар дараах саналтай байна.

1. Төрөөс үзүүлж буй зарим ажил, үйлчилгээг төрийн бус болон хувийн хэвшлийн байгууллагаар гүйцэтгүүлэх талаар Засгийн газраас урьд нь холбогдох шийдвэр гарган хэрэгжүүлж байгаа. Цаашид зөвлөмжийн дагуу төрийн бус байгууллага, хувийн хэвшлээр гүйцэтгүүлэх чиг үүрэг, ажил үйлчилгээний жагсаалтыг тодорхой гаргаж, шийдвэрлэх болно.

2. Одоо ажиллаж буй агентлагуудын чиг үүрэг, ажил үйлчилгээ нь төрөөс зайлшгүй хэрэгжүүлэх чиг үүрэг, ажил үйлчилгээ мөн эсэхийг хянаж, агентлагуудын бүтэц, зохион байгуулалтыг оновчтой болгох чиглэлээр холбогдох арга хэмжээ авах гэсэн зөвлөмжийн хувьд агентлагуудыг татан буулгах, яамдын чиг үүрэгт нэгтгэх асуудлыг зөвхөн орон тоо, төсөв хэмнэх зорилгоор бус тухайн салбарт, цаашид улс орны эдийн засаг нийгмийн хөгжилд урт хугацаанд үзүүлэх нөлөөллийг нарийвчлан тооцож, бүтэц зохион байгуулалтыг оновчтой болгох чиглэлээр нарийвчлан судалж, шийдвэрлэх нь зүйтэй гэж үзэж байна.



ТЭРГҮҮН ДЭД ДАРГА

Ж.СҮХБААТАР

Зарим агентлаг, төвүүдийн бүтэц, зохион байгуулалтыг өөрчлөх санал, түүний үндэслэл

Өөрчлөлт оруулахаар санал болгож буй			Өөрчлөлт оруулах санал	Үндэслэл		
Эрхлэх асуудлын хүрээ, харьяалал	Агентлаг төвийн нэр	Чиг үүрэг		Чиг үүрэг давхардсан	Чиг үүрэг, үйлчилгээг нь бусад хуулийн этгээдээр гэрээний үндсэн дээр гүйцэтгүүлэх боломжтой	Бусад
Ерөнхий Сайд	Төрийн өмчийн хороо	Төрийн өмчийн эд хөрөнгийн эзэмшилт, хадгалалт хамгаалалтыг сайжруулах ажлыг зохион байгуулж гүйцэтгэлийг хянах, Засгийн газраас баталсан жагсаалтын дагуу эд хөрөнгийн хувьчлах ажлыг зохион байгуулж гүйцэтгэлийг тайлагнах, Төрийн өмчийн эд хөрөнгийн бүртгэл, тооллого, тайлан тэнцэл гаргах ажлыг зохион байгуулах	Төрийн өмчийн хороог татан буулгаж, зарим чиг үүргийг Сангийн яам, холбогдох бусад яамдад шилжүүлэх	Төрийн өмчийн ашиглалттай холбоотой хяналт шалгалтын талаарх чиг үүрэг бусад хяналт шалгалтын байгууллагуудтай, Төрийн өмчийн эд хөрөнгийн бүртгэл, тооллого, тайлан тэнцэл гаргах ажлыг зохион байгуулах чиг үүрэг нь Сангийн яамны Нягтлан бодох бүртгэлийн хэлтсийн чиг үүрэгтэй тус тус давхардаж байна		Өмч хувьчлалын ажлын цар хүрээ хумигдаж, өмч хувьчлах чиг үүргээ үндсэндээ хэрэгжүүлж дууссан байна. Үлдсэн цөөн объектын хувьчлал болон төрийн өмчийн төлөөлөл, хадгалалт, хамгаалалтын асуудлыг Сангийн яам болон холбогдох бусад яамд хариуцан гүйцэтгэх боломжтой.
	Мэдээлэл, харилцаа холбоо, технологийн газар	Төрөөс мэдээлэл, харилцаа холбоо, технологийн талаар баримтлах бодлого боловсруулах, хууль эрх зүйн орчныг шинэчлэх. Мэдээлэл харилцаа холбоо, технологийн ололтыг Нийгэм эдийн засгийн бүх л салбарт нэвтрүүлнэ. Мэдээлжсэн нийгэм байгуулах үндсэн суурийг бүрдүүлнэ.	Мэдээлэл, харилцаа холбоо, технологийн газрыг татан буулгаж хэрэгжүүлж буй чиг үүргийг ЗТАЖЯ-ны холбогдох хэлтэст нэгтгэх.			Хэрэгжүүлж буй чиг үүргийг ЗТАЖЯ гүйцэтгэх боломжтой.

Шадар Сайд	Шударга бус өрсөлдөөнийг хянан зохицуулах газар	Аж ахуйн нэгжийн давамгайл болон зүй ёсны монополь байдалтай, тэр байдлаа алдсаныг тогтоох, Шударга өрсөлдөөнд харш үйл ажиллагааг хориглох, хязгаарлах, таслан зогсоох, Төрийн болон орон нутгийн захиргааны байгууллагаас гаргасан шийдвэр нь өрсөлдөөнийг хязгаарлахад чиглэсэн эсэхэд хяналт тавих, дүгнэлт гаргах	Тус газрыг татан буулгаж, чиг үүргийг Үйлдвэр худалдааны яам болон бусад холбогдох яамдад шилжүүлэх			Аж ахуйн нэгжийн давамгайл болон зүй ёсны монополь байдалтай, тэр байдлаа алдсаныг тогтоох, Шударга өрсөлдөөнд харш үйл ажиллагааг хориглох, хязгаарлах, таслан зогсоох, Төрийн болон орон нутгийн захиргааны байгууллагаас гаргасан шийдвэр нь өрсөлдөөнийг хязгаарлахад чиглэсэн эсэхэд хяналт тавих, дүгнэлт гаргах чиг үүргийг Үйлдвэр худалдааны яамны холбогдох газар, хэлтэс хариуцан гүйцэтгэх боломжтой юм.
Зам тээвэр, аялал жуулчлалын сайд	Төмөр замын хэрэг Эрхлэх газар	Салбарын хөгжлийн стратегийг боловсруулж хэрэгжүүлэх, төмөр замын тээврийн эрэлт хэрэгцээг тодорхойлж салбарын үр ашгийг нэмэгдүүлэх талаар эдийн засгийн судалгаа хийх, төмөр замын тээвэрлэлттэй холбоотой мэдээллийн сан байгуулах, мэдээ, мэдээллийг нэгтгэж дүн шинжилгээ хийх, төмөр замын тээврийн хөдөлгөөний аюулгүй байдал, тээврийн үйл ажиллагаатай холбоотой стандарт, дүрэм, журмыг боловсруулах, хэрэгжилтэнд нь хяналт тавих.	Төмөр замын хэрэг эрхлэх газрыг татан буулгаж, чиг үүргийг ЗТАЖЯ-ны тээврийн газарт шилжүүлэх	Төмөр замын хэрэг эрхлэх газрын хэрэгжүүлж буй чиг үүргүүд ЗТАЖЯ-ны Тээврийн газрын зарим чиг үүрэгтэй давхардаж байна.		Засгийн газар Төмөр замын хэрэг эрхлэх газрыг байгуулахдаа ЗГАЭЗБТХуулийн дагуу агентлаг байгуулах тухай санал, үндэслэлийг авч үнэлэлт дүгнэлт гаргаагүй байна. Өөрөөр хэлбэл энэ агентлагийг ямар ч үндэслэл, тооцоогүй байгуулсан байна. Тухайлбал ТЗХЭГ УБТЗХНН-ээс зээлээр санхүүжиж байна. Төмөр замын хэрэг эрхлэх газрын одоогийн зарим чиг үүргийг урд нь Монгол-Оросын хамтарсан УБТЗХНН орон тоо, зардалгүйгээр гүйцэтгэж байсан.

<p>Авто замын хяналт судалгааны төв</p>	<p>Олон улсын болон улсын чанартай авто замын байгууламжийн засвар, арчлалт, хамгаалалт, барилга угсралтын ажилд техникийн болон захиалагчийн хяналт тавих. Авто замын материалын хайгуул судалгааг захиалгын дагуу хийж, чанар орцын норм тогтоох түүний хэрэгжилтэд хяналт тавих. Авто зам замын байгууламжийн техник ашиглалтын түвшин тогтоох.</p>	<p>Авто замын хяналт судалгааны төвийг татан буулгаж мэргэжлийн хяналтын газрын Авто замын хяналтын албатай нэгтгэх</p>	<p>Авто замын хяналт судалгааны төвийн хэрэгжүүлж буй чиг үүргүүд мэргэжлийн хяналтын газрын авто замын хяналтын газрын чиг үүрэгтэй давхардаж байна.</p>		
<p>Тээврийн үйлчилгээний төв</p>	<p>Замын барилга угсралтын ажил, ачаа болон зорчигч тээвэрлэлтийн ажил, үйлчилгээнд хяналт тавих, авто тээврийн үйлчилгээ үзүүлэх, Авто тээврийн тухай хууль түүнд нийцүүлсэн дүрэм журам, стандартуудын хэрэгжилтийг хангуулах, Дотоодын шуудан тээвэрлэлтийн ажил үйлчилгээг зохицуулах, Хил хамгаалах Ерөнхий газар, Гаалийн ерөнхий газартай хамтарч хилийн боомтын үйл ажиллагааг байнгын болон зохион байгуулах ажлын хэсэгт авто тээврийн төлөөллийг оролцуулах, Улаанбаатар хотод тээврийн хэрэгслийн техникийн хяналтын үзлэгийн төвүүдийг ашиглалтад оруулж хэвийн ажиллагааг хангана. Тээврийн хэрэгслийн техникийн хяналтын үзлэгийн төвүүдийн хэвийн найдвартай ажиллагааг хангуулах, үзлэгийг жилийн турш зохион байгуулж, тээврийн хэрэгслийн бүртгэлийн сүлжээг бий болгоно.</p>	<p>Тээврийн үйлчилгээний төвийн Хяналт шалгалтын албаны чиг үүргийг Улсын мэргэжлийн хяналтын газрын Дэд бүтцийн хяналтын улсын албанд, Тээвэр зохицуулалтын хэлтсийн чиг үүргийг Хотын тээврийн зохицуулалтын газарт шилжүүлж Тамгын хэлтэс, Санхүүгийн хэлтсийг татан буулгаж, Техник хяналтын хэлтсийн чиг үүргийг мэргэжлийн байгууллагаар гэрээний үндсэн дээр гүйцэтгүүлэх боломжтой гэж үзэж байна.</p>	<p>Тээврийн үйлчилгээний төвийн Хяналт шалгалтын албаны чиг үүрэг нь Улсын мэргэжлийн хяналтын газрын Дэд бүтцийн хяналтын улсын албаны зарим чиг үүрэгтэй давхардаж байна. Тээвэр зохицуулалтын хэлтсийн чиг үүрэг нь Хотын тээврийн газрын зарим чиг үүрэгтэй давхардаж байна.</p>	<p>Техник хяналтын хэлтсийн чиг үүргийг мэргэжлийн байгууллагаар гэрээний үндсэн дээр гүйцэтгүүлэх боломжтой байна.</p>	

<p>Түлш эрчим хүчний сайд</p>	<p>Эрчим хүчний судалгаа хөгжлийн төв, Сэргээгдэх эрчим хүчний төв</p>	<p>Эрчим хүчний салбарт, гадаад дотоодын хөрөнгө оруулалтаар төсөл хэрэгжүүлэх, улсын төсвийн хөрөнгөөр шинээр болон шинэчлэн баригдах объектуудад захиалагчийн үүрэг гүйцэтгэж, техник хяналт тавина</p>	<p>Сэргээгдэх эрчим хүчний төвийг татан буулгаж, чиг үүргийг Эрчим хүчний судалгаа хөгжлийн төвд нэгтгэж Агентлаг болгох.</p>	<p>Сэргээгдэх эрчим хүчний төв болон Түлш эрчим хүчний судалгаа хөгжлийн төвийн чиг үүрэг үндсэндээ ижил байна.</p>	<p>Засгийн газрын 2005 оны 160 дугаар тогтоолоор Сэргээгдэх эрчим хүчний корпораци, Нарны гэрэл төслийн нэгж, Нарны зайны үйлдвэрийг татан буулгаж Сэргээгдэх эрчим хүчний төвийг байгуулсан байна. Сэргээгдэх эрчим хүчний төв нь Эрдэм шинжилгээний, Маркетингийн гэсэн 2 албатай ажиллаж байна. Энэ 2 албын үүрэг нь Эрчим хүчний судалгааны төвийн Түлшний судалгаа хөгжлийн хэлтэс, Захиалагч, техник хяналтын хэлтсийн чиг үүрэгтэй давхардаж байгаа тул энэ 2 төвийг нэгтгэх боломжтой байна.</p>
<p>Барилга хот байгуулалтын сайд</p>	<p>Орон сууцны Үндэсний төв</p>	<p>Хүн амыг орон сууцаар хангах, төрийн бодлого төсөл хөтөлбөр түүний уялдаа үр нөлөөг судлах, шаардагдах судалгаа зөвлөмжөөр яамыг хангах, төрөөс орон сууцны бодлого боловсруулахад дэмжлэг үзүүлэх, Засгийн газрын орон сууц хөтөлбөрийг хэрэгжүүлэх</p>	<p>Орон сууцны Үндэсний төийг татан буулгаж, чиг үүргийг Барилга, хот байгуулалтын яаманд шилжүүлэх</p>	<p>Орон сууцны Үндэсний төвийн чиг үүрэг Барилга нийтийн аж ахуйн хөгжлийг дэмжих төвийн чиг үүрэгтэй давхардаж байна.</p>	<p>Барилга нийтийн аж ахуйн хөгжлийг дэмжих төв нь Монгол улсын барилга орон сууц, нийтийн аж ахуйн салбарын хөгжлийн ойрын жилүүдийн зорилт болон хэтийн төлөв чиг баримтлалыг хэрэгжүүлэхэд мэргэжлийн тусалцаа, дэмжлэг үйлчилгээгээр хангах ажлыг хөрөнгө хүчний боломжид тулгуурлан хэрэгцээ, техник технологи, хэрэглээний шаардлагад нийцүүлэн дэс дараатай зохион байгуулна гэсэн чиг үүргийг хэрэгжүүлж байна.</p>

Байгаль орчны сайд	Усны хэмнэлтийн төв	Усны нөөцийг зохистой ашиглах, хамгаалах, нөхөн сэргээх, хэмнэлттэй техник технологи нэвтрүүлэх, усны нөөц ашигласны тодорхой хэсгийг төвлөрүүлэх	Усны хэмнэлтийн төвийг татан буулгаж, хэрэгжүүлж буй чиг үүргийг Усны Хэрэг эрхлэх газарт шилжүүлэх	Усны хэрэг эрхлэх газрын "Усны нөөцийг зохистой ашиглах, хамгаалах, нөхөн сэргээх талаар төр засгаас гаргасан бодлого шийдвэрийг хэрэгжүүлэх, усны нөөц ашигласны төлбөр хураамжийн орлогыг төвлөрүүлэн зохих журмын дагуу хуваарилах" гэсэн үүрэг нь Усны хэмнэлтийн төвийн чиг үүрэгтэй давхардаж байна.		
	Ус цаг уур, орчны шинжилгээний газар	Ус цаг уур, орчны шинжилгээний үнэн зөв мэдээллээр хэрэглэгчдийн хангах	Агентлагийн бүтцээс гаргаж, шинжлэх ухааны байгууллагын жишгээр ажиллуулах			Шинжлэх ухааны байгууллагын жишгээр ажиллуулах
Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга	Удирдлагын академи	Төрийн захиргааны болон бизнесийн удирдах ажилтныг сургаж бэлдэх, Төрийн бодлого, удирдлагын асуудлаар эрдэм шинжилгээ шуурхай судалгааны ажил эрхлэх	Агентлагийн бүтцээс гаргаж, боловсролын байгууллагын жишгээр ажиллуулах			Боловсролын байгууллагын жишгээр ажиллуулах
Мэргэжлийн хяналтын асуудал эрхэлсэн сайд	Улсын мэргэжлийн хяналтын газрын санхүүгийн хяналт, шалгалтын алба	Төрийн өмчийн болон төрийн өмчийн оролцоотой аж ахуйн нэгж, төсвийн санхүүжилт авдаг байгууллагуудын санхүүгийн үйл ажиллагаанд хяналт шалгалт хийж, төвлөрсөн болон орон нутгийн төсөв, тусгай зориулалтын сангийн бүрдүүлэлт, зарцуулалт, Засгийн газрын шугамаар авсан зээл, тусламжийн хөрөнгийн ашиглалтыг шалгаж, үнэлэлт дүгнэлт өгөх	Улсын мэргэжлийн хяналтын газрын санхүүгийн хяналт, шалгалтын албаны чиг үүргийг Сангийн яам болон бусад салбарын яамдад шилжүүлж, дотоод аудитын нэгжүүд байгуулах			Яамдад дотоод аудитын чиг үүрэг, тогтолцоо дутагдаж Сангийн яам энэ чиглэлээр тодорхой ажил зохион байгуулж үр дүнд хүрч байна.